

**БАЯНГОЛ ДҮҮРГИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТЭД ЯВЦЫН ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.06.16

Улаанбаатар хот

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол, 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журмын 4.2 "Байгууллага захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргах бөгөөд хяналт – шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж эхний хагас жилд явцын хяналт – шинжилгээ, жилийн эцэст хяналт – шинжилгээ үнэлгээ хийнэ", 4.9 "Төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт – шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлнэ гэснийг удирдлага болгон Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд явцын хяналт – шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай:

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО.

Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний биелэлтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт - шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ.

Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журмын 4.2 "Байгууллага захиргаа, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргах бөгөөд хяналт – шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж эхний хагас жилд явцын хяналт – шинжилгээ, жилийн эцэст хяналт – шинжилгээ үнэлгээ хийнэ" заалтыг удирдлага болгов.

"Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д тусгагдсан 4 зорилтын 39 арга хэмжээний хүрээнд хийсэн ажлын биелэлт, тайлантай танилцах, судлах түүнд хавсаргасан мэдээ, мэдээллийг ашиглан хяналт-шинжилгээ, үнэлгээг хийв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилийн эхний хагас жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо.

Үүнд:

- "үр дүнтэй" – 100 хувь,
- "тодорхой үр дүнд хүрсэн" – 70 – 99 хүртэл хувь,
- "эрчимжүүлэх шаардлагатай" – 31 – 69 хүртэл хувь,
- "үр дүнгүй" – 0 – 30 хүртэл хувь гэж үнэлгээг гаргалаа.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН.

Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хамаарах 39 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд явцын хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг хувьчлан дүгнэв.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилт от түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах							
Үндсэн чиг үүрэг-1: Идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй арга хэлбэрээр зохион байгуулах							
Зорилт-1: Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох, зорилт бүхий биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх	Арга хэмжээ-1: Аж ахуйн нэгж байгууллагын биеийн тамирын үйл ажиллагааг сайжруулах ажлын хүрээнд хамтлагийн тоог нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 5.000.0	Биеийн тамирын хамтлагийн нийт тоо	2024 онд биеийн тамирын 22 хамтлаг	24 хамтлаг	Аж ахуй нэгж байгууллагын биеийн тамирын хамтлагийн тоог 24 болгон нэмэгдүүлсэн.	100%
	Арга хэмжээ-2: Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилд иргэдийг тогтмол хамруулж заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож мөрдүүлэх, насны бүлэг, ажил амьдралын онцлогт нийцсэн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх ажлыг зохион байгуулна	Улсын төсөв 543.0	Сорилд хамрагдсан хүн амын эзлэх хувь, тэдгээрээс А,В,С-гийн эзлэх хувь	2024 онд Хүн амын 12% хамрагд аж А,В,С-гийн эзлэх хувь 49.5% хувь	Хүн амын 12,5%-г хамруул А,В,С-гийн эзлэх хувийг 49.7 хувьд хүрсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар эрэгтэй 9807 иргэн, эмэгтэй 10041 иргэн нийт 19848 иргэн бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдсан. Энэ нь дүүргийн нийт иргэний 7.9% байна. А,В,С-гийн эзлэх хувь 66.88%. Бие бялдрын түвшин тогтоох "Сорилын төв"-ийг байгуулж 2025.01 сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Тус төвийн Бие бялдрын түвшин тогтоох сорилд 200 иргэн, Биеийн бүтцийн шинжилгээнд 336 иргэн нийт 536 иргэн үйлчлүүлсэн байна.	63,2%

Дүүргийн засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баянгол дүүргийн 60 жилийн ой Нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээн, төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулна.	Арга хэмжээ-3: Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрсэн иргэд болон хүүхдүүдийн дунд биеийн тамир спортын арга хэмжээг зохион байгуулж хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 7.500	Зохион байгуулсан арга хэмжээн ий тоо, оролцогчдын тоо	2024 онд 6 арга хэмжээ 110 иргэн	6 арга хэмжээ 120 иргэн	Дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн дунд 6 арга хэмжээ зохион байгуулж 31 багийн 175 тамирчин оролцсон.	100%
	Арга хэмжээ-4: Дүүргийн ахмадуудын дунд биеийн тамир, спортын арга хэмжээ зохион байгуулж хамрах хүрээг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 7.000 0	Зохион байгуулсан арга хэмжээн ий тоо, хамрагсдын тоо	2024 онд 6 арга хэмжээ 330 ахмад	6 арга хэмжээ 350 ахмад	2025 оны хагас жилийн байдлаар ахмадын дунд 3 арга хэмжээ зохион байгуулж 57 хорооны 492 ахмадыг оролцуулсан	50%
	Арга хэмжээ-5: Жил бүр зохион байгуулагддаг Улаанбаатар марафон олон улсын гүйлтийн бүртгэлийг зохион байгуулж дүүргийн иргэдийг идэвхтэй хамруулна.	-	Олон улсын гүйлтэд бүртгүүлэн оролцсон иргэдийн тоо	2024 онд 1400 иргэн	1450 иргэн	Дүүргийн 312 иргэнийг хамруулж 3100 иргэнд дугаар олгосон.	100%
	Арга хэмжээ – 6: Дүүргийн СӨБ, ЕБС-ийн хүүхдүүд рүү хандсан нийтийн биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв 10.00 0 0	Уламжлалт болон зохион байгуулсан тэмцээн ий тоо, хамрагдсан иргэдийн тоо	2024 онд 3 арга хэмжээ 350 иргэн	3 арга хэмжээ 360 хүүхэд	СӨБ, ЕБС-ын хүүхдүүдийн дунд 2 арга хэмжээ зохион байгуулж 47 байгууллагын 920 хүүхдүүдийг хамруулсан.	66.6
	Арга хэмжээ-7: Дүүргийн төр захиргааны байгууллага, сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн багш ажилтан, албан хаагчдын дунд жил бүр спортын тэмцээн уралдааныг зохион байгуулна.	Улсын төсөв 15.80 0.0	Арга хэмжээн ий тоо хамрагдсан иргэдийн тоо	2024 онд 3 арга хэмжээ 580 иргэн	3 арга хэмжээ 700 иргэн	2025 оны эхний хагас жилийн байдлаар 2 арга хэмжээ зохион байгуулж 812 ажилтан, албан хаагчийн хамруулсан байна.	66,6

	Арга хэмжээ-8: Дүүргийн иргэдийн спортын наадмыг зохион байгуулах. Нийслэлийн иргэдийн спортын наадамд амжилттай оролцуулах	Улсын төсөв 15 000 00	Спортын төрлийн тоо хамрагдсан иргэдийн тоо	2024 онд 9 төрөл 1780 иргэн	9 төрөл 1800 иргэн	Зохион байгуулагдах төлөвлөсөн хугацаа болоогүй	0
	Арга хэмжээ-9: Дүүргийн 18-30 насны залуучуудын дунд Анхдугаар их наадмыг зохион байгуулах.	Улсын төсөв 15 000 00	Спортын төрлийн тоо хамрагдсан иргэдийн тоо		6 төрөл 1000 иргэн	"Дүүргийн 18-30 насны залуучуудын анхдугаар наадам"-г 2025.05.24-ны өдрөөс зохион байгуулж эхэлсэн бөгөөд эхний хагас жилийн байдлаар 3 төрлийн тэмцээнийг зохион байгуулж 586 иргэнийг хамруулсан.	50%
	Арга хэмжээ – 10: Өвлийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах, өвлийн өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв 9.000 0	Арга хэмжээ, хамрагдсан иргэдийн тоо	2024 онд 4 өдөрлөг 580 иргэн	4 өдөрлөг, арга хэмжээ 600 иргэн	Дүүргийн "Мөсний шагайн харваа"-н тэмцээнийг 2025.02.09-ны өдөр зохион байгуулж 9 хорооны 54 харваач оролцсон.	25%
	Арга хэмжээ – 11: Дүүргийн иргэд, ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот бүлгийн иргэдэд сургалт зохион байгуулна.	Улсын төсөв 1.500 0	Сургалтын тоо хамрагдсан иргэдийн тоо	2024 онд 6 сургалт	сургалт – 6	2025 оны эхний хагас жилд 3 сургалт зохион байгуулж 67 байгууллагын 103 ахмад, СӨБ-н багш нарыг хамруулсан.	50%
	Арга хэмжээ-12: Дүүргийн Засаг даргын санаачилсан "Усны боловсрол олгох" хөтөлбөрийн хүрээнд иргэдийн дунд усан спортын ач холбогдлыг таниулах олон төрлийн сургалтыг чанартай зохион байгуулж хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Хичээллэгчдийн тоо	2024 онд 2894 иргэн	2900 иргэн	БТСХорооны Усан бассейнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1469 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.	60%

	Арга хэмжээ-13: Үндэсний спортыг сурталчилсан "Нүүдэлчин" фестивалийн зохион байгуулалтад оролцох		Гүйцэтгэлийн хувь	100 хувь	100 хувь	III дугаар улиралд зохион байгуулагдана.	0%
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах							
Үндсэн чиг үүрэг-2: Үндэсний спортоор дамжуулан хүн амын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, ажиллах чадварыг дээшлүүлэн иргэдийн гарсан санаачилга, хүчин чармайлтыг дэмжин хөгжүүлэх							
Зорилт-2: Монгол үндэсний спортын уламжлал, ёс заншлыг залуу үед өвлүүлэн хөгжүүлнэ.	Арга хэмжээ-1: Дүүргийн хэмжээнд үндэсний спортын төрлүүдээр секц дугуйланг өсвөр үе, насанд хүрэгчдийн ангиллаар зохион байгуулна.	-	Үндэсний спортын төрлөөр хичээллэсэн секц дугуйлангийн тоо, хичээллэгчдийн тоо	2024 онд 2 төрөл 270 иргэн	3 төрөл 300 иргэн	Шагайн харваа, Үндэсний сурын харваа, Үндэсний бөх гэсэн 3 төрлөөр өсвөр үе, насанд хүрэгчдийн ангиллаар давхардсан тоогоор нийт 180 иргэн хичээллэж байна.	60%
	Арга хэмжээ-2: Дүүргийн хэмжээнд үндэсний спортын төрлүүдээр тэмцээн уралдаан зохион байгуулна.	Улсын төсөв 10.000.00	Зохион байгуулсан тэмцээн ийн төрлийн тоо, хамрагдсан иргэдийн тоо	2024 онд 3 төрөл 320 иргэн	4 төрөл 360 иргэн	2025 оны эхний хагас жилийн байдлаар дүүргийн иргэдийн дунд үндэсний спортын 4 арга хэмжээг зохион байгуулж 194 иргэнийг хамруулж ажилласан.	100%
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах							
Үндсэн чиг үүрэг-3: Спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан тамирчдын залгамж халааг бэлтгэх, өсвөрийн шигшээ багийн зохион байгуулалтыг сайжруулж тамирчдын амжилтыг улс, олон улс, тив, дэлхийн хэмжээнд хүргэх							
Зорилт-3: Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааныг зохион байгуулж төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын улс, олон улс, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж тамирчид, дасгалжуулагчдын сахилга хариуцлагыг сайжруулна.	Арга хэмжээ-1: Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтыг сайжруулах, тамирчдын үр чадварыг дээшлүүлнэ.	-	Өсвөрийн шигшээ багийн спортын төрлийн тоо ба хичээллэгсдийн тоо	2024 онд 14 төрөл 459 тамирчин	14 төрөлд 460 тамирчин	Нийт 14 төрлөөр 460 тамирчин хичээллэж байна.	100%
	Арга хэмжээ-2 Хүүхэд залуучууд, иргэдийн спортын авьяасыг нээн илрүүлж шилдэг тамирчдын залгамж халааг бэлтгэх хүрээнд үндэсний	Улсын төсөв 28.725.0	Улс, нийслэлийн спортын наадмуудын анхан шатны арга хэмжээг зохион байгуулж шигшээ тэмцээн	2023 онд Хүүхдийн өвөл, зуны спортын VII наадамд 23 төрлөөр 247 тамирчин 2022 онд Бүх ард	Хүүхдийн өвөл, зуны спортын VIII наадам, Бүх ард түмний зуны XVI наадам	Хүүхдийн өвлийн спортын VIII наадам 2025.02.17-23-ны өдрүүдэд Улаанбаатар хот болон Орхон аймагт зохион нийт 31 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 4 алтан медаль хүртсэн амжилттай оролцсон.	60%

хэмжээний спортын наадмуудын анхан шатны арга хэмжээг зохион байгуулж шигшээ тэмцээнд оролцоно.		Д оролцсо н төрлийн тоо	түмний зуны XV наадамд 26 төрлөөр 298 тамирчин		Хүүхдийн зуны спортын VIII наадам 2025.05.26-ны өдрөөс 2025.06.06-ны өдрийг дуустал Улаанбаатар хот болон Төв аймагт зохион байгуулагдаж багш, дасгалжуулагч, тамирчин, хариуцсан мэргэжилтэн нийт 347 хүний бүрэлдэхүүнтэй оролцож 18 алт, 19 мөнгө, 20 хүрэл медаль хүртсэн амжилттай оролцож улсын хэмжээнд 4 дүгээр байрт шалгарсан.	
Арга хэмжээ-3: Өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	Улсын төсөв 15.00 0.0	Зохион байгуулсан спортын төрлийн тоо, тэмцээн ий тоо	2024 онд 14 төрөл 14 тэмцээн	14 төрөл 14 тэмцээн	Хүүхдийн зуны спортын VIII наадам зохион байгуулагдахтай холбогдуулан дүүргийн өсвөр үеийн аварга шалгаруулах 16 төрлийн тэмцээнийг зохион байгуулж давхардсан тоогоор 348 байгууллагын 11923 хүүхэд хамрагдсан байна.	100%
Арга хэмжээ-4: Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн баг тамирчдын ур чадварыг дээшлүүлэн улс, олон улс, тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоог нэмэгдүүлнэ.		Оролцсон нийслэл, улс, олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн ий тоо, авсан медаль	2024 онд Өсвөрийн шигшээ баг 27 тэмцээн 156 медаль	80 тэмцээн 200 медаль	Өсвөр үеийн шигшээ багийн тамирчид 1 дүгээр улирлын байдлаар Олон улсын тэмцээнээс 5 алт, 11 мөнгө, 9 хүрэл, Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 23 алт, 26 мөнгө, 28 хүрэл, Нэрэмжит тэмцээнээс 11 алт, 6 мөнгө, 17 хүрэл медаль тус тус хүртэж спортын 14 төрлөөр 136 медаль хүртсэн.	68%
Арга хэмжээ-5: Дүүрэгтээ нийслэл, улс, олон улсын чанартай тэмцээн зохион байгуулна.		Зохион байгуулсан тэмцээн ий тоо	2024 онд 6 тэмцээн	6 тэмцээн зохион байгуулна	2025 оны хагас жилд нийслэл, улс, олон улсын чанартай 7 тэмцээнийг спорт зааландаа зохион байгууллаа.	100%
Арга хэмжээ-6: Шинээр ажилд орсон багш, дасгалжуулагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтад хамруулна.		Сургалтад хамрагдсан багш, дасгалжуулагчийн тоо	2024 онд 5 дасгалжуулагч	5 багш, дасгалжуулагч	2-4-р улиралд төлөвлөсөн.	0

	Арга хэмжээ-7: Тамирчид, дасгалжуулагч нарын ёс зүйн дүрэм, хэм хэмжээг мөрдүүлэх, сэтгэл зүй, хоол зүй, допингийн хор хөнөөлийн тухай сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.	Улсын төсөв 2.792.1	Зохион байгуулсан сургалтын тоо ба хамрагсдын тоо	2024 онд 11 сургалт тамирчин - 53 дасгалжуулагч - 82	сургалт - 7 тамирчин - 100 дасгалжуулагч - 14	2-4-р улиралд төлөвлөсөн	0
	Арга хэмжээ-8: Биеийн тамир, спортын зарим чиг үүргийг гэрээний дагуу мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагуудад шилжүүлэн хамтарч ажиллах	-	Гэрээний дагуу спортын холбоодод шилжүүлсэн ажлын тоо	2024 онд 10-н ТББ	8 ТББ 8	2025 оны эхний хагас жилийн байдлаар 9 ТББ, холбоодтой хамтарч ажилласан.	100%
	Арга хэмжээ-9: Дүүргийн биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтад хамруулна.		Сургалтад хамруулсан арга зүйчдийн тоо	2024 онд 30 арга зүйч	30 арга зүйч	2-4-р улиралд төлөвлөсөн.	0
	Арга хэмжээ-10: Өсвөрийн шигшээ багийн багш дасгалжуулагч нарт мэргэжил арга зүйн сургалт зөвлөгөө өгч ажиллана.		Зохион байгуулсан сургалтын тоо ба хамрагсдын тоо	2023 онд 13 дасгалжуулагч	14 дасгалжуулагч	2-4-р улиралд төлөвлөсөн.	0
Ерөнхий чиг үүргийн нэр: Биеийн тамир, спортын бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийг хангах							
Үндсэн чиг үүрэг-4: Төрийн байгууллагын чиг үүргийг хангах							
Зорилт-4: Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийг ханган мөрдөнө.	Арга хэмжээ-1: ЗГХЭГазрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын дагуу байгууллагын албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлагналтын үйл ажиллагааг дүгнэх, хууль журамд заасан хугацаанд харьяалах дээд шатны байгууллагад тайлагнана.	-	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь	100%	100%	Байгууллагын албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж 1, 2 дугаар улирлын гүйцэтгэлийн тайланг дүгнэж ажиллалаа.	50%

Арга хэмжээ-2: Биеийн тамир спортын салбарын хүрээнд батлагдсан бодлогын бичиг баримтуудын хэрэгжилтийг хангаж харьяалах дээд шатны байгууллагад тайлагнана.	-	Бодлогын бичиг баримтуудын хэрэгжилтийн тайланг хүргүүлнэ.	100%	100%	Нийслэлийн биеийн тамир, спортын газарт ирүүлэх тайлан, мэдээний жагсаалтын дагуу 1, 2 дугаар улирлын тайланг албан бичгийн дагуу хүргүүлж ажилласан.	50%
Арга хэмжээ-3: Байгууллагын урсгал төсвийг төлөвлөн, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулж гүйцэтгэлийг тайлагнана.	-	Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн хувь	100%	100%	Байгууллагын төсвийг зориулалтын дагуу зарцуулж Аудит-н дүгнэлт гаргуулсан. Төсвийн зарцуулалтын тайлан мэдээг тухай бүр холбогдох албан тушаалтанд гарган өгч ажиллаж байна	50%
Арга хэмжээ-4: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган хууль журмын дагуу холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг хангана.	-	Шилэн дансны мэдээллийг оруулсан хувь	100%	100%	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж Шилэн дансны мэдээллийг заалт бүрээр мэдээллийн программд хуулийн хугацаанд байршуулан санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.	50%
Арга хэмжээ-5: Санхүүжүүлсэн төсвийн хүрээнд өр, авлага үүсгэхгүй батлагдсан төсөвтөө багтаан ажиллах, үр ашиггүй зардлыг багасган ажиллана.	-	Байгууллагын төсвийн зарцуулалт ба үр ашиггүй зардлыг багасгасан хувь	100 хувь	100 хувь	Эхний хагас жилийн байдлаар Өр авлага үүсээгүй, батлагдсан төсвийг ЗГ-н 388-р тогтоолын дагуу үр ашигтай хэмнэлттэй зарцуулан ажиллаж байна.	50%
Арга хэмжээ-6: Байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг биелүүлэн ажиллана.	-	Байгууллагын үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь	100 хувь	100 хувь	2025 оны эхний хагас жилийн байдлаар үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөний дагуу орлогыг биелүүлэн ажилласан.	50%

Арга хэмжээ-7: Засгийн газрын 2011 оны 311 тогтоолыг үндэслэн байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулна.	-	Байгууллагад үүсэж болзошгүй зөрчил дутагдал гаргаах сурьдчилсан сэргийлж ажиллан	Зөрчил дутагдал байхгүй	Эрсдэл эс сэргийлэн, дотоод ажил сайжирна	Байгууллагын дотоод хяналт шалгалт зохион байгуулах зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж байна.	50%
Арга хэмжээ-8: Биеийн тамир спортын арга хэмжээ, спортын мэдээллийн цахим санг бүрдүүлэн шуурхай бодитой байх зарчмыг ханган мэдээллээ тогтмол тасралтгүй оруулж мэдээллийн сангаа баяжуулан ажиллана.	-	Мэдээллийн сангийн үйл ажиллагааг цахимаар үзүүлдэг болох	100 хувь	100 хувь	Шуурхай, нээлттэй ил тод байх зарчмын дагуу байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулагдсан нийтийн биеийн тамирын арга хэмжээ болон спортын тэмцээний мэдээллийг "Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хороо"-ны Facebook хаяг, bayangol@sport.gov.mn сайтаар тасралтгүй ард иргэдэд хүргэж байна.	50%
Арга хэмжээ-9: Байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулах, ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангах жилийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	95 хувь	96 хувь	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах, хангах сургалтын төлөвлөгөөг нэгдүгээр улиралд баталсан. Сургалтын төлөвлөгөөний хүрээнд албан хаагчдыг Насан туршийн суралцахуйн төвтэй хамтарч 2, 3 дугаар улиралд 5 удаагийн сургалтад хамруулахаар ажиллаж байна.	50%
Арга хэмжээ-10: Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн сайтад байршуулж харьяалах дээд шатны байгууллагуудад тогтмол тайлагнана.	-	Ил тод байдлыг хангасан тайланг хүргүүлсэн тоо	4 удаа хүргүүлсэн	Улирал бүр хүргүүлсэн байна.	Биеийн тамирын улсын хороо, Дүүргийн ЗДТГ, Нийслэлийн биеийн тамир, спортын газарт байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн сайтад байршуулсан тухай тайланг хугацаанд нь хүргүүлж ажилласан. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1 дүгээр улирал, хагас жилийн биелэлтийг тайлагнан ажиллаж байна.	50%

	Арга хэмжээ – 11: Байгууллагын архив, бичиг хэргийн талаар жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, албан хөтлөлт, өргөдөл гомдлын программ ашиглалтыг сайжруулж холбогдох хууль журмын хүрээнд хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Байгууллагын архив, бичиг хэргийн 2025 оны төлөвлөгөөг баталсан. 2024 онд үүссэн захирамжлалын баримт бичигт цахим үүсгэн "Archive edoc"-т шивж Баянгол дүүргийн Архивын тасагт актаар хүлээлцсэн. Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2025 оны нэгдүгээр улиралд 2024 оны жилийн эцсийн архивын материалыг хэлтэс, албан хаагчдаас авч архивт нөхөн бүрдүүлэлт хийсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар байгууллага болон алба хаагчдад холбогдох өргөдөл, санал ирээгүй 3 гомдол ирснийг хуулийн дагуу шийдвэрлэж холбогдох судалгааг гаргаж ажилласан.	100%
	Арга хэмжээ – 12: Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх, бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай" тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана.		Хэрэгжилтийн хувь	100%	100%	Монгол хэлний тухай хуулийн дагуу ажилтан албан хаагчдад Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Албан бичгийг хос бичгээр боловсруулах анхан шатны сургалтыг хийсэн. Монгол бичгийн хэвлэмэл хуудасны захиалгыг Нийслэлийн архивын газар хүргүүлж 2025.04.14 өдрөөс албан бичгийг хос бичгээр хөтлөн хэвшсэн.	100%
	Арга хэмжээ – 13: "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажлын хүрээнд арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах		Тарьсан модны тоо	Хайлаас мод 10 ширхэг	Хайлаас мод 15 ширхэг	МУ-н Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд дүүргийн ЗД-н захирамжаар батлагдсан хуваарийн дагуу 98 дугаар цэцэрлэгийн хашаанд 10 ширхэг нарс, 200 ширхэг шар хуайс мод тарьсан	100%

						Мөн Монголын усан спорт сургалтын клуб ТББ-тай хамтарч байгууллагын гадна талбайд 4 ширхэг гацуур, 200 ширхэг шар хуайс модыг тарьсан.	
	Арга хэмжээ – 14: Жендерийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн хүрээнд сургалт зохион байгуулах		Сургалт ын тоо	Сургалт 1	Сургалт т 1	3 дугаар улиралд сургалт авахаар төлөвлөн ажиллаж байна.	0
Нийт гүйцэтгэлийн хувь:							61,55

Зорилт тус бүрийн хэрэгжилтийн үр дүн:

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ
1	Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын зан төлөв насан туршийн дадал олгох, зорилт бүхий биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх	13	56,3%
2	Монгол үндэсний спортын уламжлал, ёс заншлыг залуу үед өвлүүлэн хөгжүүлнэ.	2	80%
3	Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн уралдааныг зохион байгуулж төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэн, хүний нөөцийг мэргэшүүлэх, тамирчдын улс, олон улс, тив, дэлхийд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж тамирчид, дасгалжуулагчдын сахилга хариуцлагыг сайжруулна.	10	52,8%
4	Биеийн тамир, спортын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон төрөөс биеийн тамир, спортын талаар баримталж буй бодлого шийдвэрийг ханган мөрдөнө.	14	57,1%
Зорилтын дундаж			61,55%

Арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарын үзүүлэлт:

Үнэлгээ	Арга хэмжээ		
	Тоо	Эзлэх хувь	Хяналт- шинжилгээ, үнэлгээний зөрүү
100	11	28,2	-
70-99	0	0	-
31-69	20	51,3	-
0-30	8	20,5	-

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.

1. "Баянгол дүүргийн биеийн тамир, спортын хорооны 2025 оны эхний хагас жилийн тайлан"-д дурдсанаас үр дүн зорилт 1-д нийт 13 арга хэмжээнээс 13 үнэлэгдэж 56,3 хувьтай, зорилт 2-т нийт 2 арга хэмжээнээс 2 үнэлэгдэж 80 хувьтай, зорилт 3-т нийт 10 арга хэмжээнээс 10 арга хэмжээ үнэлэгдэж 52,8 хувьтай, зорилт 4-т 14 арга хэмжээнээс 14 арга хэмжээ үнэлэгдэж 57,1 хувьтай тус тус үнэлэгдлээ. 2025 оны эхний хагас жилийн тайлангийн хэрэгжилтийн үнэлгээ 61,55 хувьтай буюу "эрчимжүүлэх шаардлагатай" байна.

2. Үр дүнтэй арга хэмжээ нийт арга хэмжээний 28,2%-ийг, тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ нийт арга хэмжээний 0%-ийг, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээ нийт арга хэмжээний 51,3%-ийг, үр дүнгүй арга хэмжээ нийт арга хэмжээний 20,5%-ийг /хугацаа болоогүй 7 арга хэмжээ/ тус тус эзэлж байна.

3. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн үр дүнг 50%-д хүрсэн байхаар тооцсон ба биелэлт нь 61,55% байгаа нь эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 100% биелэлттэй байна.

4. Жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100%-д хүргэхийн тулд хугацаа болоогүй буюу 2025 оны 3, 4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн 7 арга хэмжээг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх шаардлагатай байна.

5. Эрчимжүүлэх шаардлагатай 20 арга хэмжээг анхааралдаа авч биелэлтийг 100%-д хүргэхээр нэмэлт чиг үүрэг өгч төлөвлөгөө гарган ажиллах шаардлагатай.

ТАВ. ЗӨВЛӨМЖ.

1. Хугацаа болоогүй буюу 2025 оны гурав, дөрөвдүгээр улиралд хийхээр төлөвлөсөн ажлыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьд хүргэх зорилт тавин ажиллах.

2. Ажлын ачааллыг тэнцвэржүүлж арга хэмжээний зохион байгуулалтыг нэмэлт чиг үүрэг өгч хэрэгжүүлэх

ХЯНАСАН:
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ХОРООНЫ ДАРГА



/Г.БАТБАЯР/

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

/А.НАМЧИНХАНД/